

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ОЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

/“Төрийн мэдээлэл”, 2012 он, №22/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Ойн тухай хууль тогтоомж

2.1.Ойн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“ой” гэж мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог нөхцөл бүхий орчныг;

3.1.2.“оин сан” гэж энэ хуулийн 3.1.1-д заасан ой, ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй болон оин тэлэн ургахад шаардлагатай талбай бүхий орчныг;

3.1.3.“оин нөөц” гэж оиг талбай, ургаа модны эзлэхүүнээр нь илэрхийлснийг;

3.1.4.“ашиглах нөөц” гэж оин экосистемийн тэнцвэрт байдлыг хангах нөхцөлтэйгөөр тодорхой хугацаанд авч ашиглаж болох модны дээд хэмжээг;

3.1.5.“эзэмшлийн ой” гэж оин нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний үндсэн дээр тодорхой хугацаанд хариуцан хамгаалж, эзэмшиж, ашиглаж байгаа оин сангийн тодорхой хэсгийг;

3.1.6.“оин менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн оин аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг;

3.1.7.“оин экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж оин нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээний экологи-эдийн засгийн үр өгөөжийг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг;

3.1.8.“оин нөхөрлөл” гэж Иргэний хуулийн 481.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.8-д заасны дагуу зохион байгууллагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн сайн дурын байгууллагыг;

3.1.9.“оиг хамгаалах” гэж ой, хээрийн түймэр болон хөнөөлт шавж, өвчин зэрэг оин төлөв байдлыг доройтуулах хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, оин баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр оин нөөцийн даацад тохируулан зохистой

ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавьж гарсан зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагааг;

3.1.10.“оиг ашиглах” гэж ойн сангаас зохих журам, заавар, стандартын дагуу ойн баялгийн даацад тохируулан мод, ойн дагалт баялгийг бэлтгэх үйл ажиллагааг;

3.1.11.“ойн баялаг” гэж ойн модны нөөц, түүний дагалт баялгийн нөөцийг;

3.1.12.“ойн дагалт баялаг” гэж ойн сангийн газарт ургадаг жимс, жимсгэнэ, мөөг, самар, эмийн болон хүнс, тэжээл, техникийн ургамал, модны холтос, үйс, хусны шүүс, давирхай, ойн хөвд, хөвхөн зэрэг ойгоос авч ашиглаж байгаа аливаа баялгийн нөөцийг;

3.1.13.“ой зохион байгуулалт” гэж ойн талбай, нөөц, тархац, бүрэлдэхүүний хэмжээ, чанар, төлөв байдал, өөрчлөлтийг судлан тогтоож, ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлох үйл ажиллагааг;

3.1.14.“ой үржүүлэг” гэж урьд өмнө нь ой байгаагүй газарт таримал ой ургуулахыг;

3.1.15.“ойн цэвэрлэгээ” гэж ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах чадваргүй болж үхжиж унасан хуурай мод, гишүү, мөчир, мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг цэвэрлэх замаар ойг хамгаалах, ойн төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг;

3.1.16.“ойн санд үзүүлэх хортой нөлөөлөл” гэж аж ахуйн болон үлдэвэрлэлийн үйл ажиллагааны явцад ойн санг бүрдүүлэгч хүчин зүйлийн даац чадавхид хохирол учруулсан, ойг бохирдуулж, улмаар ойн төлөв байдлыг доройтуулсан бүхий л сөрөг үлдлийг;

3.1.17.“түймрийн аюултай үе” гэж тухайн нутаг дэвсгэрт ой, хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилт бүхий цаг хугацаа буюу жил бүрийн 3 дугаар 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацааг;

3.1.18.“ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх” гэж төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ой, хээрийн түймэр ҮҮСЭЖ тархахаас сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа мэдээлэл, сургалт, сурталчилгааны болон ойн аж ахуйн арга хэмжээг;

3.1.19.“ой, хээрийн түймрийг илрүүлэх” гэж түймэр гарсан тухайн газрын байр зүй, тархалтын хэмжээг тодорхойлох болон түймрийн голомтыг олж тогтоохыг;

3.1.20.“хил дамнасан ой, хээрийн түймэр” гэж тухайн улсын хил болон хилийн дагуух бүс нутагт гарсан ой, хээрийн түймэр өргөжин дэлгэрч хоёр улсын хилийн зааг, хил дамнаж гарсныг;

3.1.21.“ой, хээрийн түймрээс учирсан хохирол” гэж түймрийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, байгаль-экологи, эд материалд учирсан хохирол, ой, хээрийн түймэр унтраахад гарсан зардлыг;

3.1.22.“ой, хээрийн түймрээс учирсан экологийн хохирол” гэж түймрийн нөлөөгөөр байгаль-экологийн тогтолцооны хэвийн байдал, ой, түүний хөрс, ус хамгаалах экологийн үүрэг ач холбогдол алдагдах, амьтан, ургамал устах болон тэдгээрийн төрөл зүйлийн амьдрах орчин дорийтох, байгалийн нөөц, баялаг хомсдохыг;

3.1.23.“ой, хээрийн түймрээс учирсан эд материалын хохирол” гэж түймрийн нөлөөгөөр барилга байгууламж, мал, амьтан, ургамал, өвс тэжээл, малын хашаа саравч, машин тоног төхөөрөмж, гэр, орон сууц, эд материал зэрэг үндсэн ба эргэлтийн хөрөнгө гэмтэх, устах зэргээр улс орон, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд учирсан шууд хохирлыг;

3.1.24.“ой, хээрийн түймрийн хор уршиг” гэж Гамшгаас хамгаалах тухай хууль-ийн 4.1.10-т заасныг;

4 дүгээр зүйл. Таримал ойг өмчлөх, ойн санг эзэмшиүүлэх

4.1. Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу ойн нөөц нь төрийн өмч мөн бөгөөд гагцхүү ард түмний мэдэлд байна.

4.2.Хууль тогтоомжид заасан журмын дагуу иргэн өөрийн өмчлөлийн болон эзэмшлийн газартаа, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газартаа өөрийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ой модыг өмчилж болно.

4.3.Энэ хуулийн 4.2-т заасны дагуу таримал ой, түүний дагалт баялгийг өмчлүүлэх асуудлыг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын дүгнэлт, нутгийн захиргааны байгууллага болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/-ын тодорхойлолтыг үндэслэн энэ хуулийн 30.5-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

4.4.Ойн нөөц болон ойн санг дор дурдсанаар эзэмшүүлнэ:

4.4.1.төрийн захиргааны төв байгууллага ойн нөөцийг аймаг, нийслэл, сум, дүүргийн эзэмшилд;

4.4.2.сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн ойн сангийн тодорхой хэсгийг тогтоосон хугацаа, нөхцөл, болзолтойгоор гэрээний дагуу ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад.

4.5.Энэ хуулийн 4.4.2-т заасан гэрээг зохих бэлтгэл хангуулах зорилгоор эхний ээлжид нэг жилийн хугацаагаар, цаашид арван жилийн давтамжтайгаар 60 хүртэл жилийн хугацаагаар байгуулж болно.

4.6.Энэ хуулийн 4.4.2-т заасан гэрээний дагуу эзэмшүүлж байгаа ойн сангийн тодорхой хэсэг нь эзэмшлийн ойд хамаарна.

4.7.Энэ хуулийн 4.4.2-т заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч нь ойн менежментийн төлөвлөгөөний дагуу эзэмшлийнхээ ойг хамгаалах, энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу мод, дагалт баялгийг ашиглах, ойд арчилгаа, цэвэрлэгээ явуулах, нөхөн сэргээх арга хэмжээг авна.

4.8.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол эзэмшлийн ой нь хамгаалалт, ашиглалтын аль ч бусэд хамаарч болно.

4.9.Засгийн газар хамгаалалтын бусэд хамаарах эзэмшлийн ойн сангийн нэршлийн жагсаалтыг зориулалт, экологи, эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг харгалзан тогтооно.

4.10.Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх журмыг Засгийн газар батална.

4.11.Энэ хуулийн 4.4.2-т заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн ойд хохирол учруулахгүйгээр иргэн аялал зугаалгаар явах, мал туувар дайран өнгөрөх, зөгий үржүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр ойн дагалт баялгийг ашиглах, ан хийж болно.

4.12.Энэ хуулийн 4.6-д заасан эзэмшлийн ойд эзэмшигчээс бусад этгээд төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хуульд заасан үндэслэл, журмын дагуу мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах тохиолдолд тухайн ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, арчлахад гарсан зардлын тодорхой хувийг ойн санг гэрээгээр эзэмшигчид төлнө.

4.13.Энэ хуулийн 4.12-т заасан зардлыг төлөх журам, аргачлалыг төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

5 дугаар зүйл.Ойн сангийн ангилал, ойн сангийн газар

5.1.Хамгаалалт, ашиглалтын хэлбэр, экологи эдийн засгийн ач холбогдлыг нь харгалzan ойн санг дор дурдсанаар ангилна:

5.1.1.хамгаалалтын бүсийн ой;

5.1.2.ашиглалтын бүсийн ой.

5.2.Ой бүхий газар, таримал ой, бут сөөг, мод бэлтгэсэн, ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн цоорхой, түүнчлэн ойн захаас гадагш 100 метр газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай нь ойн сангийн газарт хамаарна.

6 дугаар зүйл.Ойн мэдээллийн сангийн тогтолцоо, журам

6.1.Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ойн төлөв байдал, ойн сангийн эзлэх талбайн хэмжээ, нөөц, бүрэлдэхүүн, үнэлгээ, тэдгээрийн өөрчлөлт, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний талаарх цогц мэдээллийг агуулсан улсын хэмжээний ойн мэдээллийн сантай

байна. /Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.3. Энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн долдугаар бүлэгт заасны дагуу зохицуулна.

6.4. Бүх шатны Засаг дарга ой, хээрийн түймрийн цагийн байдлын тухай мэдээг дээд шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тогтмол хугацаанд шуурхай мэдээлнэ.

6.5. Ой, хээрийн түймрийн талаарх мэдээ, тайланг аймаг, нийслэлийн Засаг дарга хагас, бүтэн жилээр гаргаж, төрийн захиргааны төв байгууллага болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өгнө.

7 дугаар зүйл.Ой зохион байгуулалт, түүний санхүүжилт

7.1. Ой зохион байгуулалтын ажлыг төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан ойн мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

7.2. Ойн сангийн тооллого, ой зохион байгуулалтын ажлыг арван жил тутамд нэг удаа хийж, түүний нөөц, төлөв байдлыг улсын хэмжээнд шинэчлэн тогтооно.

7.3. Байгалийн гамшиг, ой, хээрийн түймэр, ойн хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн зэрэг онцгой тохиолдолд ой зохион байгуулалтыг энэ хуулийн 7.2-т заасан хугацааг харгалзахгүйгээр хийж болно.

7.4. Ой зохион байгуулалтыг дараах байдлаар санхүүжүүлнэ:

7.4.1. ойн сангийн нөөцийг тогтоох, бүс нутгийн хөгжлийн төлөв байдлыг тодорхойлохтой холбогдсон хамгаалалтын болон ашиглалтын бүсийн оид ой зохион байгуулалтын ажлыг хийх, улсын ойн

менежментийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах зардлыг улсын төсвөөс;

7.4.2.хамгаалалтын бүс тогтоох болон ашиглалтын бүсийн ойд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр ой зохион байгуулалт хийх, ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс;

7.4.3.гэрээний дагуу ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа ойд хийх ой зохион байгуулалтын ажил, ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг тэдгээрийн хөрөнгөөр, харин анх удаа ойн нөхөрлөлийн эзэмшилд олгогдож байгаа ойн сангийн тодорхой хэсэгт хийх ой зохион байгуулалтыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр.

7.5.Ой зохион байгуулалт хийх журмыг Засгийн газар батална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ОЙН БҮС, ТЭДГЭЭРИЙН ХАМГААЛАЛТЫН ДЭГЛЭМ

8 дугаар зүйл.Хамгаалалтын бүсийн ой, түүний дэглэм

8.1.Хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурvasын ой, заган ой, баянбүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс илүү налуу газрын ой хамаарна.

8.2.Хориотой зурvasын ойд нуур, рашаан, булаг, шандын ундаргын эргэн тойрон болон голын эргээс хоёр тийш 1000 метрийн доторх ой, улсын чанартай авто болон төмөр замын дагуу хоёр талын 100 метрийн доторх ой хамаарна.

8.3.Усны хагалбар дахь байгаль орчны тэнцлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх зорилгоор цармын бүслүүрийн ойн заагийг төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

8.4.Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн хамгаалалтын дэглэмийг Т зохицуулна.

8.5.Байгаль орчны тэнцэл, хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг хангах зорилгоор нийслэл, хот, тосгоны ногоон бүсэд хамаарах ойн заагийг дор дурдсанаар тогтооно:

8.5.1.нийслэлийн ногоон бүсэд хамаарах ойн заагийг Засгийн газар;

8.5.2.нийслэлээс бусад хотын 30 хүртэл километрийн доторх ногоон бүсэд хамаарах ойн заагийг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага;

8.5.3.төв, суурин газрын ногоон бүсэд хамаарах ойн заагийг тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал.

8.6.Хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурvas гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

9 дүгээр зүйл.Ашиглалтын бүсийн ой, түүний дэглэм

9.1.Энэ хуулийн 8 дугаар зүйлд зааснаас бусад ой ашиглалтын бүсийн ойд хамаарна.

9.2.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ашиглалтын бүсийн ойгоос мод, ойн дагалт баялгийг зохих төлбөр, хураамжийг төлсний үндсэн дээр ашиглах эрхтэй.

9.3.Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойн санг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тусгасан ойн менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулна.

10 дугаар зүйл.Улсын тусгай хэрэгцээний газрын ойд

явуулах ойн аж ахуйн арга хэмжээ

10.1.Улсын тусгай хэрэгцээний газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг тусгай журмаар зохицуулна.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан журмыг холбогдох газрын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална./Энэ хэсгийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

10.3.Улсын тусгай хэрэгцээний газрын ойг ашиглах журмыг Засгийн газар батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ

БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

11 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

11.1.Улсын Их Хурал ойн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаарх төрийн бодлогыг тодорхойлох;

11.1.2.ойн нөөц ашигласны төлбөрийн доод, дээд хувь, хэмжээг тогтоох;

11.1.3.ойн болон ой, хээрийн түймрийн асуудлаарх олон улсын гэрээ, хэлэлцээр соёрхон батлах, цуцлах;

11.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

12 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

12.1.Засгийн газар ойн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.мод, ойн дагалт баялгийг ашиглах, импортлох, экспортлох хэмжээг хуульд заасан үндэслэлээр хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох;

12.1.2.ойн болон ой, хээрийг түймрээс хамгаалах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх;

12.1.3.ойн үндэсний хөтөлбөрийг батлах;

12.1.4.ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ойн нөөц бүхий газар нутгийн ашиглалтын бүсийн ойд замын хайгуул хийж, зураг, төсөв боловсруулах, ойн төв зам барьж байгуулах арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсөвт тусгах;

12.1.5.ойн нөөц, төлөв байдал, ашиглалтын эрчимжилтээс хамааруулан ойн ангийн хариуцах талбайн, норматив, байршлыг батлах;

12.1.6.ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам болон холбогдох бусад журам, түүнчлэн түймэртэй тэмцэхэд шаардагдах техник хэрэгслийн нормативыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний онцлогтой уялдуулан баталж мөрдүүлэх;

12.1.7.ой, хээрийн түймрийн аюултай үед хүн хүч, техник хэрэгслийн дайчилгаа зарлах, явуулах журмыг батлах;

12.1.8.ой, хээрийн түймрийг унтраах үйл ажиллагаанд оролцож байгаа иргэдийн хангамж, тэдний эзэмшсэн байх арга техник, зайлшгүй байх багаж, техник хэрэгслийн жагсаалтыг батлах;

12.1.9.ой, хээрийн түймрийн улмаас байгаль орчинд учирсан хохирлыг арилгах, экологийн тэнцлийг хангах зорилгоор газар, ой, ургамал, амьтны баялгийг ашиглах хэмжээг хязгаарлах, зогсоох;

12.1.10.хуульд заасан бусад бүрэн эрх.

12.2.Засгийн газар нь ойгоос мод бэлтгэх, ойн зам барих, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох тарьц, суулгац үржүүлэх асуудлыг хариуцах чиг Үүрэг бүхий төрийн өмчит хуулийн этгээд байгуулж болно.

13 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

13.1.Төрийн захиргааны төв байгууллага нь ойн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой хээрийг түймрээс хамгаалах, байгаль орчны тэнцлийг хангах талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

13.1.2.хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд оиг хамгаалах талаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх дүрэм, журам, бусад шийдвэрийг баталж, биелэлтийг хангуулах;

13.1.3.оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар салбар дундын болон бус нутаг хоорондын зохицуулалт хийх, эрх бүхий байгууллагаар стандарт батлуулах, холбогдох эрх зүйн актыг дангаараа буюу төрийн захиргааны холбогдох байгууллагатай хамтран баталж, биелэлтийг зохион байгуулах;

13.1.4.жил бүр ашиглах ойн нөөцийн дээд хэмжээг модны төрлөөр хууль тогтоомжийн дагуу тогтоох;

13.1.5.экологийн шаардлага, нөөцийг харгалзан тухайн бус нутагт мод, ойн дагалт баялгийн ашиглалтыг хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох;

13.1.6.улсын ойн менежментийн төлөвлөгөөг батлах;

13.1.7.энэ хуулийн 12.1.3-т заасан хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих;

13.1.8.ойн нөөцийн төлөв байдал, чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх, нөөцийн өөрчлөлт, ашиглалт, хамгаалалтын байдлыг хянах;

13.1.9.улсын ойн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавих;

13.1.10.оийн мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, хүчингүй болгох;

13.1.11.энэ хуулийн 7.4.1-д заасны дагуу улсын төсвөөс гаргах зардлын хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, биелэлтийг дүгнэн, ажил гүйцэтгэгчийг санхүүжүүлэх;

13.1.12.оийн нөөцийг хамгаалах дотоод хяналтыг зохион байгуулах;

13.1.13.оийн экологи, эдийн засгийн үнэлгээг боловсруулах, батлах; [Энэ заалтад 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

13.1.14.оий, хээрийн түймэр гарах өндөр магадлалтай үед хариуцсан нутаг дэвсгэртээ хамгаалалтын дэглэмд заасан зарим үйл ажиллагааг хориглох эрхийг улсын тусгай хамгаалалттай газрын захиргаанд олгох;

13.1.15.хил дамнасан оий, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах талаар бусад улстай гэрээ, хэлэлцээр байгуулж, хамтран ажиллах;

13.1.16.цаг агаарын болон оий, хээрийн түймрийн цагийн байдлын тухай мэдээллээр холбогдох байгууллага, хүн амыг хангах;

13.1.17.оий, хээрийг түймэр, хөнөөлт шавжийн тархалт, оийн нөөцийн хомсдол, газрын доройтол, бохирдоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, оийн ашиглалттай холбоотой гарсан зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

13.1.18.аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх; [Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.1.19.мод бэлтгэсэн, оий, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, говь, хээрийг ойжуулах, ойн зурvas байгуулах, төв, суурин газрыг цэцэрлэгжүүлэх ажлыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулах; [Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.1.20.мод, сөөгийн үрийн нөөцийн сан бүрдүүлэх, мод үржүүлгийн газар байгуулах, тарьц, суулгац ургуулах ажлыг улсын хэмжээнд

мэргэжлийн удирдлагаар хангах; [Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн.](#)

13.1.21.орон нутаг дахь ойн анги, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих; [Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн.](#)

13.1.22.ойн ангийн ажиллах журам, дурмийг батлах; [Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн.](#)

13.1.23.оиг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнах; [Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн.](#)

13.1.24.оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар технологи, норм, нормативын үндэслэл боловсруулах, батлах; [Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн.](#)

13.1.25.ойн нөөцийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх, ойн мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллээр хангах болон аж ахуйн нэгж, байгууллага мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулахад тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах; [Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн.](#)

13.1.26.оиг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх ажилд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулахад бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх; [Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн.](#)

13.1.27.оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын явуулах үйл ажиллагааны хөтөлбөр, ойн ангийн эрхлэх ажил, үйлчилгээний чиглэл, ойн менежментийн төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, тэдгээрийг боловсруулах заавар, журам батлах; [Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн.](#)

13.1.28.хамгаалалтын бусийн ойг цэвэрлэх, арчлах, түймрийн шороон болон халз зурvas гаргах зэрэг ой, хээрийн түймрээс хамгаалах ойн аж ахуйн арга хэмжээг улсын хэмжээнд төлөвлөж, шаардагдах зардлыг

улсын болон орон нутгийн төсөвт тусгуулах замаар хэрэгжүүлэх; [/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.1.29.ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ой, хээрийн түймэр унтраах арга, ажиллагаанд сургах ажлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх; [/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.1.30.ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрийн түймрээс сэрэмжлүүлэх, орон нутагт эргүүл, харуул ажиллуулах болон энэ ажилд бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах; [/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.1.31.ой, хээрийн түймрийн аюултай үед тухайн бүс нутгийн түймрийн аюулын анги, зэрэглэлийг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгаль орчинтой харьцах тодорхой үйл ажиллагааг зогсоох тухай саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх; [/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.1.32.нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ой, хээрийн түймрээс хамгаалах талаар зохион байгуулж байгаа ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, хамтран оролцох; [/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.1.33.ой, хээрийн түймрийн гаралт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай зарлан мэдээлэх; [/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.1.34.өөрийн байгууллагын бүтцэд ойн судалгаа, хяналт шинжилгээний алба ажиллуулах; [/Энэ заалтыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.1.35.хуульд заасан бусад бүрэн эрх. [/Энэ заалтын дугаарыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчилсөн./](#)

14 дугээр зүйл.Ойн асуудал эрхэлсэн нэгж

/Энэ зүйлийн гарчигт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

14.1.Аймаг, нийслэлийн байгаль орчны газрын бүрэлдэхүүнд ойн асуудал хариуцсан нэгж буюу ойн асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтан, аймаг, суманд сум дундын болон сумын ойн анги /цаашид “ойн анги” гэх/ ажиллана. /Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

14.2./Энэ хэсгийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

15 дугаар зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллагын бүрэн эрх

15.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.энэ хуулийн 12.1.7-д заасан журмын дагуу дайчилгаа явуулж, гарсан ой, хээрийн түймрийг унтраах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

15.1.2.хүн амыг ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, унтраах арга ажиллагаанд сургах сургалт, сурталчилгаа зохион байгуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

15.1.3.ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн бүс нутагт байгаль орчинтой харьцах тодорхой үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох.

16 дугаар зүйл.Цагдаагийн байгууллагын бүрэн эрх

16.1.Цагдаагийн байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.ой хээрийн түймрийн шалтгаан, эзэн холбогдгчийг тогтоох;

16.1.2.ой хээрийн түймрийн аюултай үед ойд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглох.

17 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

17.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, биелэлтэд хяналт тавих;

17.1.2.оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, ойн сангийн төлөв байдал, мэдээллийн сангийн тухай Засаг даргын мэдээлэл, тайланг сонсох;

17.1.3.Засаг даргын саналыг үндэслэн ойн сангийн тодорхой хэсгийг орон нутгийн хамгаалалтад авах, түүний хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоох, биелэлтэд нь хяналт тавих;

17.1.4.төрийн захиргааны төв байгууллагын баталсан дээд хязгаарт багтаан тухайн жилд ойгоос бэлтгэх хэрэглээний мод, түлээний хэмжээг сумдаар хуваарилан батлах;

17.1.5.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэртээ ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

17.1.6.оин талбайн хэмжээний нормативыг харгалзан нутаг дэвсгэртээ байх ойн ангийн жагсаалт, тухайн жилийн төсвийг батлах.

17.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.2.1.оин тухай хууль тогтоомж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

17.2.2.оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, биелэлтийг хангах;

17.2.3.оин сангийн мэдээ, тайланг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх; [Энэ заалтад 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан.](#)

17.2.4.тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээний талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх; [Энэ заалтад 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан.](#)

17.2.5.ой, хээрийн түймрээс учирсан хохирлын хэмжээг тогтоолгож, байгаль орчныг нөхөн сэргээх талаар улсын захиалга өгч, судалгаа-шинжилгээний ажил гүйцэтгүүлэх, үр дүнг тооцож, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

17.2.6.оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагааны явцад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, шаардлагатай бол ойн санд сөргөөр нөлөөлж байгаа үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх, зогсоох;

17.2.7.оин хөнөөлт шавж, өвчин, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгах, оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс шаардагдах хөрөнгийг батлуулах, хэрэгжүүлэх;

17.2.8.аймгийн байгаль орчны газрын харьянд сум дундын ойн анги, нийслэлийн байгаль орчны газарт ойн асуудал эрхэлсэн нэгж байгуулж, бүтэц, орон тоо, дүрмийг батлан, тэдгээрийн даргыг байгаль орчны газрын даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх;

17.2.9.оиг нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг жил бүр зохион байгуулж, түүний биелэлтэд хяналт тавих;

17.2.10.ой бүхий сум, дүүргийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

17.2.11.Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14.1.2-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, багаж хэрэгсэл, хүнс болон бусад зүйлийн байнгын нөөцийг Засгийн газраас тогтоосон нормативын дагуу бий болгон шинэчлэн сэлгэж байх;

17.2.12.Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14.1.4-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

17.2.13.ой, хээрийн түймэр гарсан үед бүрэн эрхийнхээ хүрээнд хүн хүч, техник хэрэгслийг дайчлан тухайн түймэр унтраах ажлыг шуурхай зохион байгуулах;

17.2.14.иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, унтраах, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалах арга, ажиллагаанд сургаж дадлагажуулах ажлын төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх;

17.2.15.улсын хилийн дагуух ой, хээрийн түймрээс хамгаалах ойн зурvasыг бий болгох, тэдгээрийг байнга сэргээх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр, хилийн бүсэд ойн арчилгаа болон цэвэрлэгээний ажлыг орон нутгийн хөрөнгөөр зохион байгуулах;

17.2.16.ой, хээрийн түймэр унтраахад дайчлах гамшигаас хамгаалах алба, штаб, мэргэжлийн ангиудыг томилон, бэлэн байдлыг хангуулах, ой, хээрийн түймэр унтраах ажлыг шуурхай зохион байгуулж удирдлагаар хангаж ажиллах;

17.2.17.ой, хээрт гарсан түймрийг иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хүн хүч, техник хэрэгслээр газар авахуулахгүй унтраасан бол ой, хээрийн түймэр унтраахад гарсан зардлыг орон нутгийн төсвөөс олгох бөгөөд хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;

17.2.18.ой, хээрийн түймрийн аюултай үед ойд мод бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглах, ойд аялал, зугаалгаар явах болон бусад үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авах;

17.2.19.ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг бууруулах, арилгах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх;

17.2.20.ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар сум, орон нутгийн түвшинд зохиож байгаа ажилд хяналт тавих;

17.2.21.ой, хээрийн түймрийн голомтод ажиллах иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг шаардагдах тоног төхөөрөмж, хүнсээр хангах ажилд хяналт тавих.

17.3.Аймаг, нийслэлийн Байгаль орчны газар нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.3.1.хариуцсан нутаг дэвсгэртээ ойн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж, дүнг аймаг, нийслэлийн Засаг дарга, болон төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах; [/Энэ заалтад 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

17.3.2.аймаг, нийслэлийн ойн мэдээллийн санг бүрдүүлж, төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах; [/Энэ заалтад 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.3.3.өөрийн харьяа ойн ангийг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

17.3.4.оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаарх саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх, шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны төв байгууллагад тавих; [/Энэ заалтад 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

17.3.5.мэргэжлийн байгууллагаар ой, хээрийн түймрийн гаралт, хөнөөлт шавж, өвчний тархалт болон ойн баялгийн судалгааг хийлгэх захиалга өгөх;

17.3.6.ойн нөөц ашигласны төлбөр, хураамжийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулж, төвлөрүүлэх;

- 17.3.7.нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах;
- 17.3.8.өөрийн газарт ойн нэгж буюу ойн асуудал эрхэлсэн албан тушаалтан ажиллуулах, ойн ангийн даргыг томилох, чөлөөлөх тухай саналаа тухайн шатны Засаг даргад мэдүүлэх;
- 17.3.9.ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 17.3.10.оиг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх зориулалтаар төсвөөс хуваарилсан хөрөнгийг гэрээ байгуулан гүйцэтгэгчид олгож, түүний зарцуулалтад хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнах;
- 17.3.11.ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар сум, орон нутгийн түвшинд зохиож байгаа ажилд хяналт тавих.

18 дугаар зүйл.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

- 18.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 18.1.1.оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээнд шаардагдах төсвийг батлах, биелэлтэд хяналт тавих;
- 18.1.2.хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу тухайн жилд ашиглах ойн нөөцийн хэмжээг тогтоох;
- 18.1.3.оиг хамгаалах талаар Засаг даргаас хэрэгжүүлсэн ажлын тайлан хэлэлцэх, шийдвэр гаргах;
- 18.1.4.баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшүүлэх асуудлыг шийдвэрлэх, хяналт тавих;

18.1.5.оин нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлсэн гэрээний биелэлтийг жил бүр хэлэлцэн дүгнэж байх;

18.1.6.оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх бодлого, чиглэлийг батлах, хяналт тавих;

18.1.7.шаардлагатай тохиолдолд ойн анги болон ойн асуудал эрхэлсэн албан тушаалтан ажиллуулах, шаардагдах төсвийг батлах;

18.1.8.нутаг дэвсгэртээ ой, хээрийн түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх төлөвлөгөө, төсөв баталж, хэрэгжилтэд хяналт тавих.

18.2.Сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.2.1.оин тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

18.2.2.оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

18.2.3.энэ хуулийн 34.1, 38.1-д заасны дагуу эрхийн бичиг, гарал Үүслийн гэрчилгээг олгоход хяналт тавих, уг эрхийн бичиг, гэрчилгээг үндэслэлгүй олгосон нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгох;

18.2.4.оиг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах талаарх ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, тэдний тарьж ургуулсан таримал ойг хүлээн авах;

18.2.5.оий, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчин, хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, учирсан хор хөнөөлийг арилгах;

18.2.6.энэ хуулийн 18.1.4-т заасан шийдвэрийг үндэслэн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг болзол, хугацаатайгаар эзэмшүүлэх гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;

18.2.7.оин нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн сум, дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон хязгаарт багтаан мод бэлтгэх шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих;

18.2.8.оин нөөцийн бүртгэл, ой зохион байгуулалтын ажлыг өөрийн хариуцсан нутаг дэвсгэртээ ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, сумын ойн менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх;

18.2.9.оин ангийн дарга болон ойн асуудал эрхэлсэн албан тушаалтныг томилох, чөлөөлөх;

18.2.10.ой, хээрийн түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний орон нутгийн төлөвлөгөөг жил тутамд батлан хэрэгжилтийг зохион байгуулах;

18.2.11.төмөр зам, хот хоорондын зам, иргэдийн өвөлжөө, хаваржаа, үтрэм, тариалангийн талбай, ой дахь барилга, байгууламжид ой, хээрийн түймрийн хамгаалалтын зурvas хийлгэж, хүлээн авах;

18.2.12.нутаг дэвсгэртээ ой, хээрийн түймрийн аюултай үед эргүүл, харуул ажиллуулах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг энэ ажилд татан оролцуулах;

18.2.13.ой, хээрийн түймэр унтраах ажлыг удирдан зохион байгуулж, дайчилгааны дэс дараалал, хуваарийг түймрийн аюултай үе эхлэхээс өмнө жил бүр гаргаж мөрдүүлэх;

18.2.14.ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрт аялал, зугаалгаар явах, ан агнах, мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах болон бусад төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл олгож, шаардлагатай тохиолдолд дээрх үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох талаар дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

18.2.15.ой, хээрийн түймрээс учирсан хохирол, түймрийг унтраахад гарсан зардлын хэмжээг тогтоох ажлын хэсгийг томилж ажиллуулах;

18.2.16.ой, хээрийн түймэр хоёр ба түүнээс дээш сумын нутаг дэвсгэрийг хамарсан тохиолдолд түймрийг унтраахад гарсан зардлыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;

18.2.17.ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар нутаг дэвсгэртээ сургалт, сурталчилгаа явуулах болон нутгийн өрх, мод бэлтгэх үйл ажиллагаа эрхэлдэг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сан бүхий газрыг хариуцуулж, хяналт тавих;

18.2.18.ой, хээрийн түймэр унтраах ажлыг шуурхай зохион байгуулж хүн хүч, техник хэрэгслийг дайчлах, ой, хээрийн түймэр гарсан тухай болон түймрийг унтраах ажлын явцын талаарх мэдээллийг дээд шатны Засаг дарга, холбогдох бусад байгууллагад цаг хугацаанд нь шуурхай мэдээлэх;

18.2.19.ой, хээрийн түймрийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, түймэр тавьсан гэм буруутай этгээдийг тогтооход цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах.

18.3.Сум дундын болон сум, дүүргийн ойн анги нь дараах эрх, үүрэгтэй:

18.3.1.ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах;

18.3.2.бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгох;

18.3.3.сум, дүүргийнхээ мод бэлтгэсэн болон хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн газрын ойжуулалтын ажил, ойн хөнөөлт шавж, өвчний тоймчилсон судалгаа гүйцэтгэх;

18.3.4.модны үр, тарьц, суулгац худалдаалах, ойд учирсан хохирлын экологи эдийн засгийн үнэлгээ тогтоох;

18.3.5.ойн арчилгааны гэрэлжүүлэх, тохируулах огтлолтыг гүйцэтгэх болон сум, дүүргийн ойн хөтөлбөр, ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж хангуулах;

18.3.6.ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

18.3.7.ойн баялгийг ашигласны төлбөр, хураамжийг ногдуулж, тэдгээрийн гүйцэтгэлийг хангах;

18.3.8.аймаг, сумын түвшинд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж байгаа бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох;

- 18.3.9.мэдээллийн санг эрхлэх;
- 18.3.10.иргэдэд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах;
- 18.3.11.ойг ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчин зэрэг байгалийн гэнэтийн аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэдгээртэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 18.3.12.ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулж, зөрчлийг арилгах;
- 18.3.13.ойн анги нь төсөв, түүнчлэн сургалт, мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлсний болон өөрийн ажил, үйлчилгээний орлого зэрэг эх үүсвэрээс санхүүжих;
- 18.3.14.нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- 18.3.15.ой, хээрийн түймрийг унтраах ажиллагаанд сумын нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах.

19 дүгээр зүйл.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал

болон Засаг даргын бүрэн эрх

19.1.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 19.1.1.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ажлын чиглэлийг тогтоох, хэрэгжүүлэх, хяналт тавих;
- 19.1.2.ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай баг, хорооны Засаг даргын мэдээллийг сонсох;

19.1.3.оин нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх, гэрээг цуцлах санал, дүгнэлтийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад уламжлах.

19.2.Баг, хорооны Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.2.1.оин тухай хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

19.2.2.нутаг, дэвсгэртээ мод, сөөг тарих ажлыг зохион байгуулж, иргэдийг өргөнөөр оролцуулах;

19.2.3.ой, хээрийн түймрээс хамгаалах сурталчилгааг хүн бүрт хүргэж түймэртэй тэмцэх бэлтгэлийг хангуулах;

19.2.4.ой, хээрийн түймэртэй тэмцэх ажлыг шуурхай зохион байгуулах, хүн хүч, техник хэрэгслийг дайчлах, ой, хээрийн түймэр гарсан тухай болон түймрийг унтраах ажлын явцыг дээд шатны Засаг дарга болон холбогдох бусад байгууллагад шуурхай мэдээлэх;

19.2.5.нутаг дэвсгэр дэх ойн сан бүхий газруудыг тодорхой хугацаагаар иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгжид хариуцуулж хяналт тавих;

19.2.6.ой, хээрийн түймрийн шалтгаан, гаргасан этгээд, хохирлыг тогтооход эрх бүхий байгууллагад дэмжлэг үзүүлэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ИРГЭН, ОЙН НӨХӨРЛӨЛ, АЖ АХУЙН НЭГЖ,

БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

20 дугаар зүйл.Иргэний эрх, үүрэг

20.1.Иргэн ойг хамгаалах талаар дараах эрх эдэлнэ:

20.1.1.оин тухай хууль тогтоомжийг зөрчсөний улмаас ойн санд, эсхүл тухайн иргэний эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх болон учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах;

20.1.2.ойн нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа газрынхаа ойн санг эзэмших, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;

20.1.3.холбогдох байгууллагаас ойн нөөц, түүний хамгаалалт, ашиглалтын талаар үнэн, зөв мэдээлэл авах;

20.1.4.түлшний болон ахуйн хэрэглээнд шаардагдах мод бэлтгэх хүсэлтээ ойн анги /байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан/-д гаргаж, ойн мэргэжлийн байгууллага, албан тушаалтны хяналт, зааварчилгааны дагуу гүйцэтгэх.

20.2.Иргэн ойг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

20.2.1.оин тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

20.2.2.оин баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, устгаж сүйтгэсэн зөрчлийн талаар тухайн шатны Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх;

20.2.3.оиг хамгаалах үндэсний уламжлал, ёс заншлыг сахиж, хүүхэддээ экологийн хүмүүжил олгох;

20.2.4.гал түймрийн улсын хяналтын дурмийг чанд биелүүлж, түймрийн аюултай үед ил задгай гал түлэхгүй байх, асаасан шүдэнз, татсан тамхины гал, цог, нурмыг бүрэн унтрааж аюулгүй болгох;

20.2.5.гэр, байшин, хураасан өвс, хашаа, саравчны эргэн тойронд хамгаалалтын зурvas татах болон түймэр унтраах байнгын багаж хэрэгсэлтэй байх;

20.2.6.өрх бүр үнс, нурмыг тусгайллан бэлдсэн таглаа бүхий нүх, саванд хийж, түймэр алдахгүй байх нөхцөлийг хангах;

20.2.7.ой, хээрийн түймрээс амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалах, түймэр унтраах анхан шатны арга ажиллагааг эзэмшсэн байх, хүүхдээ түймрээс сээрэмжлүүлж сургах;

20.2.8.тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг галын аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох, галын аюултай бодис, шатах, тослох материалыг хадгалах горимыг чанд мөрдөх;

20.2.9.хуурай өвс, ургамлын хучаас, тариалангийн талбайн сүрэл, хог ургамал, өтөг бууцыг шатаахгүй байх;

20.2.10.ой, хээрийн түймрийг унтраах ажиллагаанд иргэний журамт Үүргийн дагуу оролцох, хувийн эзэмшлийн тээврийн хэрэгслээ ашиглуулах болон ой, хээрийн түймэр илрүүлсэн, түймрийн тухай мэдээ хүлээн авсан бол түүнийг унтраах арга хэмжээг шуурхай авч, холбогдох шатны Засаг дарга, бусад шаардлагатай байгууллагад яаралтай мэдээлэх.

21 дүгээр зүйл.Ойн нөхөрлөл, түүний эрх, үүрэг

21.1.Ойн нөхөрлөл нь энэ хуулийн 4.9, 9.3-т заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөтэй байна.

21.2.Ойн нөхөрлөл нь хууль тогтоомжид нийцсэн дүрэмтэй байна.

21.3.Ойн нөхөрлөл нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ойн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааныхаа хөтөлбөр, ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүр тавина.

21.4.Ойн нөхөрлөл нь гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн тодорхой хэсгийг ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

21.5.Ойн нөхөрлөл нь гэрээгээр эзэмшсэн газартаа Б заасны дагуу идэвхтэн байгаль хамгаалагчийг ажиллуулж болно.

21.6.Ойн нөхөрлөлийн гишүүдийн 80-аас доошгүй хувь нь гэрээгээр эзэмшиж байгаа ойн сангаа байнга харж хамгаалах, хяналт тавих боломжтой тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн байнгын оршин суугч иргэн байна.

21.7.Ойн нөхөрлөлийн гишүүн нь Б заасан шаардлагыг хангасан байна.

21.8.Ойн нөхөрлөл нь ойн сангийн тодорхой хэсгийг эзэмших давуу эрхтэй бөгөөд ойн нөхөрлөл байгуулахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

21.8.1.ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшиж хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулахыг хүссэн өргөдөл;

21.8.2.ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшихийг зөвшөөрсөн тухай баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал;

21.8.3.ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаарх ойн менежментийн төлөвлөгөө, гэрээний төсөл, гэрээгээр эзэмших ойн талбайн хилийн цэс, байршил, тархалтын зураг;

21.8.4.ойн нөхөрлөл байгуулсан гишүүдийн хамтран ажиллах тухай гэрээний хуулбар;

21.8.5.ойн нөхөрлөлийн гишүүдийн иргэний үнэмлэхийн хуулбар.

21.9.Энэ хуулийн 21.8-д заасны дагуу бүрдүүлсэн баримт бичиг нь энэ хуулийн 21.7-д заасан шаардлага, 21.8-д заасан бүрдлийг хангасан бол сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, уг шийдвэрийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгоно.

21.10.Гэрээний дагуу ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөлд эзэмшүүлэхдээ гишүүдийн тоо, чадамж, хариуцах талбай, нөөц, экологийн онцлог зэргийг харгалзана.

21.11.Дараах тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг дарга ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшиж хамгаалах чиглэлээр явуулах ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоож, гэрээг цуцална:

21.11.1.оин сангийн тодорхой хэсгийг эзэмшиж хамгаалах чиглэлээр явуулах үйл ажиллагааг зогсоох тухай баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гарсан;

21.11.2.оин нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаар ойн сангийн тодорхой хэсгийг эзэмших үйл ажиллагааг зогсоох шийдвэр гарсан;

21.11.3.энэ хуулийн 21.6, 21.7-д заасан нөхцөл, шаардлага болон энэ хуулийн 21.9-д заасны дагуу байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл гэрээ байгуулснаас хойш зургаан сарын хугацаанд ойг хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа явуулаагүй.

21.12.Энэ хуулийн 21.9-д заасны дагуу гэрээ байгуулсан ойн нөхөрлөл дараах эрхийг эдэлнэ:

21.12.1.эзэмшлийн газартаа ойн менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэх үйл ажиллагааг тасралтгүй явуулах;

21.12.2.эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах;

21.12.3.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ойн аж ахуйн арга хэмжээний төсөл, хөтөлбөр боловсруулах, санал өгөх, уралдаант шалгаруулалтад оролцох;

21.12.4.оин менежментийн талаар явуулах сургалт, семинар, мэргэжил олгох, давтан сургах үйл ажиллагаанд хамрагдах.

21.13.Оин нөхөрлөл энэ хуульд заасан үүргийг биелүүлэхийн зэрэгцээ тухайн шатны Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан үйл ажиллагааг явуулна.

22 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

22.1.Аж ахуйн нэгж, байгууллага дараах эрх, үүрэгтэй:

22.1.1.байгаль орчныг хамгаалах болон ойн тухай хууль тогтоомж, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын шийдвэр, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх;

22.1.2.оиг ашиглах чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах болон ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх;

22.1.3.ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшсэн аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 4.9, 9.3-т заасны дагуу ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр явуулах үйл ажиллагааны ойн менежментийн төлөвлөгөөг батлуулж мөрдөх;

22.1.4.ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшсэн аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийнхээ ойгоос ойн менежментийн төлөвлөгөө, гэрээ, эрхийн бичигт заасан нөхцөл, болзлын дагуу мод, ойн дагалт баялгийг ашиглах;

22.1.5.энэ хуулийн 34.4-т заасан тохиолдолд гарал үүслийн гэрчилгээг ойн анги /байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан/-аас авсан байх;

22.1.6.Б заасан нөхцөлөөр ойн сангийн эзэмшил бүхий газарт идэвхтэн байгаль хамгаалагчийг ажиллуулах;

22.1.7.ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшихийг хүссэн аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 21.8.1-21.8.3-т заасан баримт бичгийг бүрдүүлэх;

22.1.8.ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага тухайн сум, дүүргийн төсөвт зохих татвар төлөх;

22.1.9.ойн тухай хууль тогтоомжид заасан үүргийг биелүүлэх;

22.1.10.тухайн шатны Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан үйл ажиллагааг явуулах;

22.1.11.жил бүр сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн талаар тайлан тавьж, ажлаа дүгнүүлэх;

22.1.12.ой, хээрийн түймэр унтраахад хүн хүч, тээврийн болон бусад хэрэгслийг гаргаж өгөх;

22.1.13.ой, хээрт мод бэлтгэх, эрэл, хайгуул, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, хээрийн шинжилгээний анги зохион байгуулахдаа хууль тогтоомжид заасны дагуу зөвшөөрөл авч ой, хээрийн түймэр гаргахгүй байх баталгаа гарган, түймрийн аюултай үед ой, хээрт аялал, зугаалга хийх, зорчих бусад үйл ажиллагаа явуулахгүй байх;

22.1.14.галын аюултай бодис, шатах, тослох материалыг хэрэглэх, тээвэрлэх, хадгалах журам, горимыг чанд мөрдөж ажиллах;

22.1.15.бүх төрлийн тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг галын аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох, ажилд гаргахдаа шалгаж байх;

22.1.16.ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа аж ахуйн нэгж, байгууллага ой, хээрийн түймрээс хамгаалах болон унтраах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх.

22.2.Тухайн сум, дүүргийн Засаг дарга нь ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дараах үндэслэлээр зогсоож, гэрээг цуцална:

22.2.1.энэ хуулийн 21.11.1-д заасан шийдвэр гарсан;

22.2.2.энэ хуулийн 22.1.11-д заасны дагуу тайлан тавьж, ажлаа дүгнүүлээгүй;

22.2.3.энэ хуулийн 22.1.7, 22.1.8-д заасныг зөрчсөн;

22.2.4.гэрээ байгуулснаас хойш зургаан сарын хугацаанд ойг хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа явуулаагүй.

22.3.Энэ хуулийн 22.1.9-д заасан гэрээ болон гэрчилгээний загварыг төрийн захиргааны төв байгууллага батална.

23 дугаар зүйл.Ойн мэргэжлийн байгууллага, түүний үйл ажиллагаа

23.1.Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах, арга зүйн зөвлөгөөгөөр хангах эрхийг холбогдох хуулийн дагуу авсан аж ахуйн нэгж, байгууллагыг ойн мэргэжлийн байгууллага гэнэ.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан байгууллага нь өмчийн аль ч хэлбэртэй байж болох бөгөөд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна:

23.2.1.ойн баялгийн нөөцийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэх;

23.2.2.ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшиж ойг зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг гүйцэтгэх, эрх олгосон тохиолдолд нөлөөллийн үнэлгээ хийх;

23.2.3.ойг нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаа явуулахаас гадна бусад байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт явуулах, төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;

23.2.4.өөрийн гүйцэтгэсэн ажлын үнэн зөвийг хариуцаж, үйл ажиллагааныхаа талаар төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах; [Энэ заалтад 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

23.3.Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, ажиллах журмыг төрийн захиргааны төв байгууллага батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

ОЙГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ

24 дүгээр зүйл.Ойг хамгаалах арга хэмжээ

24.1.Ойг хамгаалах арга хэмжээнд ойг ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, хүний үйл ажиллагааны серөг

нөлөөллөөс хамгаалах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг хангах, удмын санг хамгаалах арга хэмжээ багтана.

24.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэрийнхээ ой бүхий газрын доройтсон хэсэгт ойн санг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор гурав хүртэлх жилийн хугацаагаар ашиглалтын үйл ажиллагааг зогсоож болно.

25 дугаар зүйл.Төрийн бус байгууллагыг ойн санг хамгаалахад оролцуулах

25.1.Ойн баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Б заасны дагуу ойг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг явуулж болно:

25.1.1.ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

25.1.2.ойг хамгаалах талаарх саналаа холбогдох төрийн байгууллага болон зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад уламжлах;

25.1.3.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

25.1.4.ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах төсөл, зөвлөмж, аргачлал боловсруулж, холбогдох байгууллагад танилцуулан шийдвэр гаргуулах, хэрэгжүүлэх;

25.2.Төрийн захиргааны төв байгууллага ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаарх төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр Б заасны дагуу ойг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.

26 дугаар зүйл.Ой, хээрийн түймрээс хамгаалах

26.1.Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн хэсгийг ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

27 дугаар дүгээр зүйл.Ойг хөнөөлт шавж, өвчинөөс хамгаалах

27.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ойг хөнөөлт шавж, өвчинөөс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх хөтөлбөр боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусгуулах арга хэмжээ авна.

27.2.Хөнөөлт шавж, өвчний тархалтын голомт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийн нутаг дэвсгэрийг хамарсан тохиолдолд түүнтэй тэмцэх ажлыг ойн мэргэжлийн байгууллага улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.

27.3.Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн тодорхой хэсгийг хөнөөлт шавж, өвчинөөс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

27.4.Хөнөөлт шавж, өвчний судалгаа явуулах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг ойн мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

27.5.Оид хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэхэд төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрснөөс бусад химиин бодис ашиглахыг хориглоно.

28 дугаар зүйл.Оид арчилгаа, цэвэрлэгээ хийх

28.1.Ойн хэвийн өсөлт, хөгжилтийг хангах, бүтээмжийг дээшлүүлэх, ойг түймэр, хөнөөлт шавж, өвчинөөс урьдчилан сэргийлэх, экологийн тэнцлийг хадгалан хамгаалах зорилгоор энэ хуулийн 28.2.1-д заасан арчилгааг зөвхөн ойн мэргэжлийн байгууллага, цэвэрлэгээг ойн мэргэжлийн байгууллагаас гадна ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, иргэн гэрээгээр хийнэ.

28.2.Ойд хийгдэх арчилгаа, цэвэрлэгээний ажлыг дараах байдлаар санхүүжүүлнэ:

28.2.1.ойд гэрэлжүүлэх, тохируулах арчилгааг улсын төсвийн хөрөнгөөр;

28.2.2.энэ хуулийн 28.2.1-д зааснаас бусад төрлийн арчилгаа болон цэвэрлэгээний ажлыг тухайн ажлыг гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр.

28.3.Төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд ойд хийх арчилгаа, цэвэрлэгээний ажлын хэмжээг Засаг даргынх нь саналыг үндэслэн аймаг, нийслэлээр тогтооно.

28.4.Ойн анги /байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан/ арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэгдсэн модонд эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгоно.

28.5.Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

29 дүгээр зүйл.Ойд хориглох үйл ажиллагаа

29.1.Ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг хангах, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс ойг хамгаалах зорилгоор дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

29.1.1.насны тавдугаар анги хүртэлх ой, бүх төрлийн өсвөр мод, түүнчлэн жодоо, яшил, заг, тоорой, жигд, яргай, сухай, гандигар, тэс болон чацааргана, мойл зэрэг бүх төрлийн жимсний мод, бутыг огтлох, хугалж гэмтээх;

29.1.2.төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр ойгоос хуш, гацуур, нарсыг бэлтгэх, ашиглах;

29.1.3.ойг хавтгайруулан огтлох аргаар мод бэлтгэх;

29.1.4. ойн сан бүхий газарт зөвшөөрөлгүйгээр өвс хадах;

29.1.5.оийжуулсан, ойн үр бэлтгэх зориулалтаар тусгаарласан болон тарьц, суулгац ургуулсан мод үржүүлгийн талбайд мод бэлтгэх, мал бэлчээх;

29.1.6.энэ хуулийн 14.1, 14.2-т заасан эрх бүхий байгууллагатай зөвшилцөхгүйгээр эзэмшлийн ойд мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах зэрэг үйл ажиллагаа явуулах;

29.1.7.иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага зохих зөвшөөрөлгүйгээр ойгоос мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, ан агнах, түймрийн аюултай үед зохих зөвшөөрөлгүйгээр аялал, зугаалгаар явах;

29.1.8.байгалийн ойгоос зулзаган модыг энэ хуулийн 14.1-д заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр шилжүүлэн суулгах;

29.1.9.барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах ажилд барилгын хэв хашмалын тулаасны зориулалтаар бөөрөнхий мод ашиглах;

29.1.10.ойн сангийн газарт улсын тусгай хэрэгцээний болон ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхээс бусад зориулалтаар барилга байгууламж барих, аливаа объект байрлуулах;

29.1.11.мод, сөөг нутагшуулах, тарималжуулахаар хийж байгаа туршилт, судалгааны ажлаас бусад тохиолдолд мод, сөөгний тарьц, суулгац импортлох.

30 дугаар зүйл.Ойг нөхөн сэргээх, үржүүлэх

30.1.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, түүнчлэн мод бэлтгэсэн талбайн ойг нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээг улсын захиалгаар улсын болон орон нутгийн төсөв, өөрийн хөрөнгө, дотоод, гадаадын хандив, тусlamжаар гүйцэтгэнэ.

30.2.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага огтолсон нэг модны оронд арав буюу түүнээс дээш тарьц суулгацыг ойд тарьж ургуулж, улсын ойн санд хүлээлгэж өгнө.

30.3. Тал хээр, говь, цөлийн бүсийг ойжуулах, гол, горхи, булаг, шандын эх, бэлчээр, тариалангийн талбайг хамгаалах зорилгоор ногоон зурvas байгуулах хөтөлбөр, төслийг улсын төсөв, бусад эх үүсвэрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

30.4. Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэхэд улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаас багагүй байна.

30.5. Ойжуулалт, ойн аж ахуйн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журмыг санхүүгийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

31 дүгээр зүйл. Мод тарьж ургуулах ажлыг зохион байгуулах

31.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга бүх нийтээр мод тарих сарын ажлыг жил бүр зохион байгуулж, 16 насанд хүрсэн иргэн бүр нэг, аж ахуйн нэгж, байгууллага таваас доошгүй мод тарьж ургуулах, услах, арчлах бөгөөд өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй тохиолдолд зардлыг хандивлана.

31.2. Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга мод суулгах талбайг сонгох, хөрс боловсруулах, тарьц суулгацаар хангах, тэдгээрийг услах, арчлах ажлыг ойн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, уг ажилд иргэдийг татан оролцуулна.

31.3. Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын тарьж ургуулсан модыг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу худалдан авч болно.

31.4. Хот, сууринг цэцэрлэгжүүлэх, ногоон байгууламж байгуулах ажлыг холбогдох хуулиар зохицуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ОЙГ АШИГЛАХ

32 дугаар зүйл.Бэлтгэж ашиглах модны хэмжээг тогтоох

32.1.Ойгоос тухайн жилд бэлтгэх модны дээд хязгаарыг аймаг, нийслэлийн Засаг даргын санал, ой зохион байгуулалтын баримт бичиг, ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэл тус бүрээр тогтооно.

32.2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээг энэ хуулийн 32.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүрэг бүрээр тогтооно.

32.3.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн энэ хуулийн 35.1, 35.2-т заасны дагуу ойгоос бэлтгэх модны төрөл, тоо хэмжээг байгууллага бүрээр тогтооно.

32.4.Шинээр мод бэлтгэсэн, ой, хээрийн түймэр, хөнөөлт шавжид нэрвэгдсэн газарт ойн орчны нөхцөл өөрчлөгдөхөөс өмнө байгалийн сэргэн ургалтыг дэмжих арга хэмжээг тухайн жилд нь мод бэлтгэгч байгууллага өөрийн хөрөнгөөр, ойг нөхөн сэргээх, үржүүлэх мэргэжлийн байгууллага орон нутгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэнэ.

32.5.Ойн сангүй болон ойн ашиглах нөөцгүй аймгуудын өрх, аж ахуйн нэгж, байгууллагын түлшний модны хэрэгцээг төвлөрсөн журмаар хангах бөгөөд түлшний модны хөнгөлөлтийн хувь, хэмжээг Засгийн газар тогтооно.

33 дугаар зүйл.Мод бэлтгэх гэрээ байгуулах

33.1.Ойн санг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллага сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн ойн анги /байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан/ -тай мод бэлтгэх гэрээ байгуулна.

33.2.Энэ хуулийн 33.1-д заасны дагуу байгуулах мод бэлтгэх гэрээнд дараах зүйлийг тусгана:

33.2.1.мод бэлтгэх үндэслэл /мод бэлтгэхийг зөвшөөрсөн тухай эрх бүхий этгээдийн шийдвэр/;

33.2.2. мод бэлтгэх хугацаа, зориулалт, бэлтгэх модны төрөл, хэмжээ;

33.2.3.мод бэлтгэлийн талбай тусгаарласан материал, мод бэлтгэх технологийн карт болон ойн нөөцийн тодорхойлолт;

33.2.4.оиг нөхөн сэргээх, ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинөөс хамгаалах төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх зардлын хэмжээ;

33.2.5.мод бэлтгэсэн талбайг хүлээлгэн өгөх нөхцөл;

33.2.6.мод бэлтгэсэн талбайг хүлээлгэн өгөх, гэрээний биелэлтийг дүгнэх.

34 дүгээр зүйл.Мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгох

34.1.Энэ хуулийн 32.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон хэмжээнд багтаан ойн анги /байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан/ иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагад мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгоно.

34.2.Энэ хуулийн 34.1-д заасан эрхийн бичигт иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын нэр, хаяг, бэлтгэх модны төрөл хэмжээ, бэлтгэх, тээвэрлэж дуусгах хугацаа, газрын нэрийг заана.

34.3.Энэ хуулийн 34.1-д заасан эрхийн бичгийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

34.4.Ойгоос бэлтгэсэн гуалин, шургааг, дүнз, зүсмэл материал, түлээг өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдахад мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээг энэ хуулийн 34.1-д заасны дагуу олгоно.

34.5.Энэ хуулийн 34.4-т заасан гарал үүслийн гэрчилгээний загвар, түүнийг олгох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

35 дугаар зүйл.Мод бэлтгэх ажиллагаа

35.1.Энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан ойн ашиглалтын чиглэлийн мэргэжлийн байгууллага нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон хэмжээнд, зөвшөөрөгдсөн дараах төрлийн огтлолтоор мод бэлтгэж болно:

35.1.1.оин төлөв байдалд сөргөөр нөлөөлж байгаа мод, бутыг огтлох замаар ой ургах тааламжтай орчныг бий болгоход чиглэсэн арчилгааны;

35.1.2.түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдэж хатсан, цаашид ургах чадваргүй болсон ойн модыг огтлох замаар ойг цэвэрлэх, ойг эрүүлжүүлэхэд чиглэгдсэн цэвэрлэгээний;

35.1.3.нас гүйцсэн модыг огтлох замаар модон түүхий эдийг бэлтгэхэд чиглэсэн үйлдвэрлэлийн ашиглалтын.

35.2.Зохих зөвшөөрөл авсан иргэн ахуйн зориулалтаар, түүнчлэн ойн санг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийнхээ талбайд энэ хуулийн 3.1.15-д заасан ойн цэвэрлэгээ хийх замаар мод бэлтгэж болно.

35.3.Зохих зөвшөөрөл авсан иргэн, түүнчлэн ойн санг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 35.2-т зааснаас өөр зориулалт, арга замаар мод бэлтгэхийг хориглоно.

35.4.Дараах тохиолдолд хууль бусаар мод бэлтгэсэн гэж үзнэ:

35.4.1.гэрээ, зөвшөөрлийн баримт бичигт заасан тоо хэмжээ хэтрүүлсэн, төрөл, зориулалт, бэлтгэх арга, технологийг зөрчиж мод бэлтгэсэн;

35.4.2.зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр мод бэлтгэсэн;

35.4.3.засварласан, хуурамч, хүчингүй гэрээ, эрхийн бичгээр ойгоос мод бэлтгэсэн.

36 дугаар зүйл.Өөр аймаг, сумын нутагт мод бэлтгэх

36.1.Өөр аймаг, сумын нутагт мод бэлтгэх бол зохих шатны Засаг дарга нар урьдчилан тохиролцож, тухайн жилд бэлтгэх модны дээд хязгаарт оруулах саналаа аймаг, нийслэлийн Засаг дарга төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ. /Энэ хэсэгт 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

36.2.Энэ хуулийн 36.1-д заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга нар мод бэлтгэх талаар тохиролцоонд хүрч чадаагүй бол төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

37 дугаар зүйл.Бэлтгэсэн модыг боловсруулах, худалдаалах

37.1.Модны чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж энэ хуулийн 35.1, 35.2-т заасны дагуу бэлтгэсэн модыг боловсруулах, худалдаалах ажлыг зохион байгуулна.

37.2.Энэ хуулийн 37.1-д заасан иргэн, аж ахуйн нэгж, түрээслэгч нь эрхийн бичиг болон гарал үүслийн гэрчилгээгүй мод, түүнчлэн хууль бусаар бэлтгэсэн модыг боловсруулах, худалдаалахыг хориглоно.

37.3.Энэ хуулийн 37.1-д заасан үйл ажиллагааг зохион байгуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж нь өөрийн түрээслэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, эрхийн бичиг болон гарал үүслийн гэрчилгээгүй мод, түүнчлэн хууль бусаар бэлтгэсэн модыг боловсруулах, худалдаалахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

38 дугаар зүйл.Ойн дагалт баялаг, түүнийг ашиглах горим

38.1.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн дагалт баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг тухайн ойн анги /байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан/ олгоно.

38.2.Энэ хуулийн 38.1-д заасан эрхийн бичигт иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, түүж бэлтгэх дагалт баялгийн төрөл, хэмжээ, хугацаа, газрын нэрийг заана.

38.3.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ойн дагалт баялгийг төлбөртэйгөөр ашиглана.

38.4.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад энэ хуулийн 38.1-д заасан эрхийн бичиг олгоходо ойн дагалт баялаг, түүний тархац, тухайн жилийн ургац зэргийг харгалзана.

38.5.Хушны самрын дунд ургацтай жилд зөвхөн ахуйн зориулалтаар, их ургацын жилд аль ч зориулалтаар ашиглахыг зөвшөөрнө.

38.6.Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааг зохицуулсан журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

38.7.Боловсруулаагүй ойн дагалт баялгийг экспортлохыг хориглоно.

38.8.Ойн сан бүхий газарт ургадаг хушны самар, зэрлэг жимс, жимсгэнэ, мөөг, эмийн ашигт ургамлыг хамгаалах бүсүүдийг байгуулж нутгийн иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлж болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

39 дүгээр зүйл.Ойг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг

39.1.Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, түүнчлэн дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах бөгөөд журмыг Засгийн газар батална.

39.2.Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, буюу илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу урамшуулал олгоно.

39.3.Хууль бусаар бэлтгэж хураалгасан гуалин, шургааг, дүнз, зүсмэл материал, түлээ зэрэг мод, модон материал, түүнчлэн дагалт баялгийн

борлуулалтын орлогын 15 хувийг тухайн зөрчлийг илрүүлсэн байгаль хамгаалагч, улсын байцаагчид Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу урамшуулал болгон олгоно.

39.4.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр бойжуулсан чанартай тарьц, суулгац, тарьсан мод, бут, сөөг, таримал ойг зохих журмын дагуу төрөөс худалдан авах буюу бусад хэлбэрээр урамшуулна.

39.5.Энэ хуулийн 39.2-39.4-т заасан урамшуулал олгох журмыг санхүүгийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

39.6.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас ойг хамгаалах, нөхөн сэргээх, үргүүлэх арга хэмжээг гүйцэтгэх, ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

39.7.Ой, хээрийн .түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, нийслэл, сум, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана.

39.8.Ой, хээрийн түймрийн хор уршгийг арилгах зардлыг улсын төсвөөс гаргаж, ой, хээрийн түймэр гарсан шалтгааныг тогтоосны дараа түүнийг гэм буруутай этгээдээр зохих хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлнэ.

39.9.Ой, хээрийн түймрийн хор уршиг, хөнөөл ихэссэн үед энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7-д заасан журмын дагуу дайчилгаа явуулахад гарсан зардлыг Засгийн газраас санхүүжүүлж болно.

40 дүгээр зүйл.Төлбөр, хураамж

40.1.Ойн баялгийн нөөц ашигласны төлбөрт ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны, ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөр хамаарна.

40.2.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага хуульд заасны дагуу дараах хураамж төлнө:

40.2.1.ойн мэргэжлийн байгууллагын эрх олгосны;

40.2.2.оин дагалт баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгосны;

40.2.3.бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгосны.

40.3.Энэ хуулийн 40.1, 40.2-т заасан төлбөр, хураамж, түүнчлэн хууль бусаар бэлтгэж хураалгасан мод, модон материал, оин дагалт баялгийг борлуулсны орлого, энэ хуулийн 42.1-д заасан нөхөн төлбөрийг хуульд заасны дагуу төсөвт оруулна.

40.4.Энэ хуулийн 40.1, 40.2-т заасан төлбөр, хураамжийн хэмжээг тогтоох, чөлөөлөх, хөнгөлөх асуудлыг холбогдох хуулиар зохицуулна.

40.5.Оин баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ болон оин мэргэжлийн байгууллагын эрх авсан этгээд уг эрхийн бичиг болон гэрчилгээний үнийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.2-т заасан Байгаль хамгаалах санд төлнө.

41 дүгээр зүйл.Оин салбарын сургалт, шинжлэх ухааны хангамж

41.1.Засгийн газар нь албан болон албан бус боловсролын тогтолцооны хүрээнд иргэдэд оин талаарх мэдлэг, боловсрол, хүмүүжил, оиг хамгаалах арга, дадал олгох экологийн боловсролын хөтөлбөрийг баталж, биелэлтийг зохион байгуулна.

41.2.Засгийн газар оин талаар баримтлах сургалт, шинжлэх ухааны хангамжийг дараах байдлаар зохион байгуулна:

41.2.1.сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуульд оин экологийн боловсрол, мод тарих, ойжуулах чиглэлээр анхны мэдлэг олгох;

41.2.2.мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, коллеж, их, дээд сургуульд оин чиглэлээр бэлтгэх мэргэжилтэй боловсон хүчиний эрэлт хэрэгцээг тогтоож, мэргэжлийн боловсрол олгох, давтан сургалтыг тогтмол явуулж, мэргэжлийн боловсон хүчин, ажилчид бэлтгэх;

41.2.3.оин салбарт судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж, дэвшилтэт арга, технологи боловсруулах, инновацийн хөрөнгө

оруулалт хийх замаар судалгааны үр дүн, шинэ санаа, дэвшилтэт техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

41.2.4.хэвлэл мэдээллийн хэрэгслээр ойн тухай мэдлэг, ойг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомжийг сурталчлах.

42 дугаар зүйл.Ойн санд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх

42.1.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага дараах үйл ажиллагаа явуулснаас ойн сан, түүний нөөцдөд хохирол учруулсан бол учирсан шууд хохирлыг нөхөн төлнө:

42.1.1.хориглосон үйл ажиллагаа явуулсан;

42.1.2.хууль бусаар мод бэлтгэсэн;

42.1.3.зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг түүсэн, бэлтгэсэн;

42.1.4.ойн санд хортой нөлөөлөл үзүүлсэн;

42.1.5.үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, ашигт малтмал олборлох зэрэг үйл ажиллагаа явуулахдаа ойг устгасан;

42.1.6.хууль бусад үйл ажиллагаа явуулсан.

42.2.Энэ хуулийн 42.1-д заасан шууд хохирол болон ойг нөхөн сэргээхэд гарсан зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр сум, дүүргийн Засаг дарга шүүхэд нэхэмжлэл гаргана.

42.3.Энэ хуулийн 42.1-д заасан шууд хохирлыг нөхөн төлсөн нь гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

42.4.Энэ хуулийн 42.1.3-т заасан ойн дагалт баялгийн нөөцийн нөхөн төлбөрийн хэмжээг тухайн үеийн зах зээлийн үнэлгээгээр, бусад нөхөн төлбөрийн хэмжээг экологи эдийн засгийн үнэлгээгээр тогтооно.

43 дугаар зүйл.Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тогтоох

43.1.Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг зохих шатны Засаг даргын шийдвэрээр байгуулсан ажлын хэсэг тухайн түймэр унтарснаас хойш 30 хоногт багтаан тогтооно.

43.2.Ой, хээрийн түймрээс учирсан хохиролд экологийн болон эд материалын хохирол, ой, хээрийн түймэртэй тэмцэхэд гарсан шууд болон шууд бус зардлыг оруулан тооцно.

43.3.Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан таримал ой болон тэдгээрийн эзэмшлийн ойд гаднаас түймэр орж хохирол учруулсан тохиолдолд хохирлын хэмжээг төр хариуцаж, ойжуулалтын ажлыг улсын хөрөнгөөр гүйцэтгэж өгнө.

44 дүгээр зүйл.Ой, хээрийн түймэр унтраах дайчилгааг зохион байгуулах

44.1.Бүх шатны Засаг дарга нар хүн хүч, техник хэрэгслийг дайчлан нутаг дэвсгэртээ гарсан ой, хээрийн түймрийг унтраах ажлыг шуурхай зохион байгуулах, түүнтэй холбогдсон Засаг даргын шаардлагыг иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага заавал биелүүлэх үүрэгтэй.

44.2.Ой, хээрийн түймэр унтраах дайчилгаанд 16 нас хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй хүн хамрагдахгүй.

44.3.Улсын хил, аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэр дамжсан орон нутгийн хүчээр унтраах боломжгүй ой, хээрийн түймэртэй тэмцэхэд шүүхээс албадан хөдөлмөр хийлгэхээр шийтгэгдсэн хүмүүсийг оролцуулах асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цэргийн ангийн асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.

44.4.Ой, хээрийн түймэр унтраах ажилд дайчлагдсан иргэдийн хүнс, бусад хангамж, тээврийн хэрэгсэл, багаж, шатахуунаар хангах асуудлыг дайчилгаа зохион байгуулж байгаа төрийн байгууллага, албан тушаалтан хариуцна.

45 дугаар зүйл.Ой, хээрийн түймэр унтраахад дайчлагдсан

иргэн, төрийн албан хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа

45.1.Ой, хээрийн түймэр унтраах ажилд дайчлагдсан иргэн, төрийн албан хаагч түймэр унтраах иргэний журамт болон албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон, амь насаа алдсан тохиолдолд түүнд буюу ар гэрт дараах тэтгэвэр, тэтгэмж, цалингийн зөрүү зардлыг олгоно:

45.1.1.хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, авч байсан цалингийн зөрүү;

45.1.2.хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, авч байсан цалингийн зөрүү;

45.1.3.хиймэл эрхтэн хийлгэх бол түүний зардал;

45.1.4.амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр, хохирогчийн авч байсан цалингийн зөрүү;

45.2.Ой, хээрийн түймэртэй тэмцэж яваад амь насаа алдсан иргэн, төрийн албан хаагчийн оршуулгын болон техник хэрэгсэл ашигласантай холбогдсон зардлыг төр хариуцна.

45.3.Ой, хээрийн түймэрт дайчлагдсан иргэн, төрийн албан хаагч түймэртэй тэмцэж яваад амь насаа алдсан тохиолдолд түүний ар гэрт нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлнэ.

45.4.Тусламжийн хэмжээг Засгийн газар тогтооно.

46 дугаар зүйл.Санхүүжилт

46.1.Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, нийслэл, сум, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана.

46.2.Ой, хээрийн түймрийн хор уршгийг арилгах зардлыг улсын төсвөөс гаргаж, түймэр гарсан шалтгааныг тогтоосны дараа түүнийг гэм буруутай этгээдээр зохих хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлнэ.

47 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

47.1.Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд зөрчлийн шинж байдал, хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

47.2.Шүүгч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, эсхүл байгаль хамгаалагч ойн тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэргүй бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

47.2.1.мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй, эсхүл мод огтлох, ойн дагалт баялгийг ашиглахдаа технологийн горимыг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

47.2.2.гэрээний дагуу эзэмшүүлсэн ойд түймэр, хөнөөлт шавж, өвчинөөс хамгаалах арга хэмжээ аваагүй бол ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

47.2.3.энэ хуульд заасны дагуу түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх шаардлагыг биелүүлээгүй иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

47.2.4.зохих эрхийн бичиггүйгээр ойгоос мод, түлээ бэлтгэсэн, ойн дагалт баялаг ашигласан, түүнчлэн гарал үүслийн гэрчилгээгүйгээр гуалин, шургааг, дунз, зүсмэл материал, түлээг тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан, эсхүл эрхийн бичигт заасан нөхцөл, болзлыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар бэлтгэсэн, тээвэрлэсэн зүйл, олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тус тус төгрөгөөр торгох;

47.2.5.гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөлсний доод хэмжээг дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

47.2.6.ойгоос мод, ойн дагалт баялгийг ойн менежментийн төлөвлөгөөнд туссан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, гэрээний заалтыг зөрчсөн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

47.2.7.энэ хуулийн 8.6-д заасныг зөрчсөн бол хууль бусаар бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

47.2.8.тухайн жилд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг хэтрүүлэн мод бэлтгэх шийдвэр гаргасан болон эрхийн бичиг олгосон, энэ хуулийн 42.2-т заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгуулах;

47.2.9.ойгоос мод бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглах гэрээ, эрхийн бичиг, бусад газарт тээвэрлэх гарал үүслийн гэрчилгээг үндэслэлгүй олгосон, эсхүл зохих бичилтийг дутуу хийсэн, засварласан эрхийн бичиг олгосон, тээвэрлэсний дараа эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг нөхөн олгосон албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

47.2.10.энэ хуулийн 37.2, 37.3-т заасныг зөрчсөн бол боловсруулсан мод, худалдаалснаас олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

47.2.11.энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан хориглосон үйл ажиллагааг явуулсан бол хууль бусаар бэлтгэсэн зүйл, олсон орлого, ашигласан тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг хурааж, иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

47.2.12.ойн санд хортой нөлөөлөл үзүүлсэн нь тогтоогдсон бол иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, энэ хуулийн 22.1.1-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дерөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох.

47.2.13.энэ хуулийн 18.2.10-18.2.18-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй сум, дүүргийн Засаг дарга, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгох, 20.2.4-20.2.10-д заасан үүргээ биелүүлээгүй иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр торгох, эсхүл 7-30 хоногоор баривчлах, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох, эсхүл тусгайлан олгосон эрхийг хоёр хүртэлх жилийн хугацаагаар хасах;

47.2.14.ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймрийг унтраах, учирсан хохирлыг арилгахад төрөөс олгосон хөрөнгийг өөр зориулалтаар ашигласан албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг нөхөн төлүүлэх.

47.3.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түймэртэй тэмцэхтэй холбогдсон үүргээ зохих ёсоор биелүүлээгүй Засаг даргад Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА
Д.ДЭМБЭРЭЛ